



ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛТЭЭНИЙ ТАЙЛАН

Байгууллагын нэр: ШУТИС-ийн Эрдэнэт цогцолбор дээд сургууль

Хөтөлбөрийн нэр: Уул уурхайн машин тоног төхөөрөмж

Индекс: 072901 бакалавр

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Оюунцэцэг. (МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхимийн багш, доктор, дэд профессор)

Гишүүд: А.Цэнгүүнжаргал. (Боловсролын ерөнхий газрын Дээд боловсролын сургалтын хөтөлбөр, орчин хариуцсан ахлах мэргэжилтэн)

Т.Цолмон. (Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн Уул уурхайн ашиглалтын технологийн тэнхимийн багш, мэргэшсэн инженер)

2024 он 02 сар 06 өдөр

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

ЭЦДС	Эрдэнэт цогцолбор дээд сургууль
PEO	Program Educational Objectives
PLO	Program Learning Outcomes
STEER	Social, Technological, Economical, Environmental, and Political
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан
БШУ	Боловсрол, шинжлэх ухаан
МУИС	Монгол улсын их сургууль
ӨҮТ	Өөрийн үнэлгээний тайлан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УУМТТ	Уул уурхайн машин тоног төхөөрөмж
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Эрдэнэт цогцолбор дээд сургууль Erdenet Complex Institute	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Уул уурхайн машин тоног төхөөрөмж Mining machinery and equipment	
Индекс	072901	
Шинжээчид	<p>Ахлагч: Д.Оюунцэцэг (МУИС-ийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхимийн багш, доктор, дэд профессор)</p> <p>Гишүүд: А.Цэнгүүнжаргал (Боловсролын ерөнхий газрын Дээд боловсролын сургалтын хөтөлбөр, орчин хариуцсан ахлах мэргэжилтэн)</p> <p>Т.Цолмон (Говьсүмбэр аймаг дахь Политехник коллежийн Уул уурхайн ашиглалтын технологийн тэнхимийн багш, мэргэшсэн инженер)</p>	
БМИҮЗ-ийн ажлын албаны мэргэжилтэн	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч Б.Оюунцэцэг	
Төлөвлөгөө	2024.01.18	Мэргэжилтэн шинжээчдэд ӨҮТ-г хүлээлгэн өгөх
	2024.01.22	Шинжээчийн урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд өгөх
	2024.01.22	Сургуулийн бэлэн байдлыг нягтлах
	2024.01.25, 26	Шинжээчид сургууль дээр ажиллах
	2024.02.06	Шинжээчийн баг зохицуулагчид шинжээчийн тайланг илгээх
		Магадлан итгэмжлэлд орж буй сургуульд шинжээчийн тайланг илгээх
		Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Шалгуур, шаардлага шинэчлэн батлах тухай” тогтоолын Гуравдугаар хавсралтаар батлагдсан шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ШУТИС-ийн харьяа, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх, Ш.Отгонбилэгийн нэрэмжит “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль нь Монгол-Зөвлөлтийн Засгийн газар хоорондын Эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын 1975 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаан, Монгол-Зөвлөлтийн хамтарсан “Эрдэнэт” үйлдвэрийн Зөвлөлийн II хурлын шийдвэр, Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн Ерөнхий захирлын 1975 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 63 тоот тушаал зэрэгт үндэслэн “Эрдэнэт” үйлдвэрийн уул уурхайн нарийн мэргэжлийн ажилчид бэлтгэх зорилгоор “Сургалтын төв” нэртэйгээр анх үүсгэн байгуулагдсан. Улмаар 1999 онд “Эрдэнэтийн технологийн сургууль, 2018 онд “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль болон өргөжсөн.

“Эрдэнэт цогцолбор” дээд сургууль нь өнөөг хүртэлх 48 жилийн хугацаанд 120 гаруй мянган хүнд уул уурхайн нарийн мэргэжил шинээр олгох, мэргэжлийн зэрэг ахиулах, хос мэргэжил эзэмшүүлэх сургалтуудыг явуулахын зэрэгцээ 462 техникумын боловсролтой, 2376 бакалаврын зэрэгтэй, 400 орчим магистрын зэрэгтэй уул уурхайн инженерүүдийг бэлтгэн гаргаж, ХХ зууны манлай бүтээн байгуулалт-Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр болон Монгол улсын уул уурхайн салбарыг нарийн мэргэжлийн ажилчид, инженер техникийн ажилтнуудаар хангахад үнэтэй хувь нэмэр оруулсан. Мөн “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль нь 2010-2014 оны хичээлийн жилд ХХI зууны томоохон бүтээн байгуулалт “Оюутолгой” ХХК-ийн үйлдвэрлэлийн бүхий л салбарын анхны 465 нарийн мэргэжлийн ажилчдыг бэлтгэн гаргаж, шинэ зууны уул уурхайн салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулжээ.

Зорилго: УУМТТ мэргэжлээр төгсөгч мэргэжлээрээ 4-5 жил ажилласны дараа уул уурхайн олборлох, боловсруулах, тээвэрлэх тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний ажлыг компьютерын зохих программ хангамж ашиглан төлөвлөх, практикийн нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх, хяналт тавих онолын мэдлэг, чадвартай бүтээлч, шинийг эрэлхийлэгч, техник ашиглалтын тэргүүний арга туршлагыг нэвтрүүлэгч мэргэжилтэн болсон байх хувь хүнийг бэлтгэхэд оршино.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learning Outcomes)

№	Хөтөлбөрийн хүрэх үр дүн (PLO)
Мэргэжлийн мэдлэг, сэтгэлгээ	
1	Мэргэжлийн шинжлэх ухааны үндсэн суурь мэдлэг
2	Мэргэжлийн цөм мэдлэг
3	Ахисан түвшинд мэргэших боломж
Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, хандлага	
4	Шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх чадвар
5	Туршилт хийх, мэдлэг бүтээх чадвар эзэмших
6	Системтэйгээр бодох чадвар
7	Хувь хүний хандлага, байнга суралцах чадвар эзэмших
8	Ёс зүйтэй байх, хариуцлага ухамсарлах чадвар эзэмших
Хүмүүстэй харилцах, багаар ажиллах ур чадвар	
9	Багаар ажиллах
10	Харилцааны ур чадвар
11	Гадаад хэлээр харилцах чадвар
Салбар ба нийгэмд чиглэсэн үр дүнтэй үйл ажиллагаа явуулах чадвар	
12	Мэргэжилтэн гаргах шийдвэрийнхээ үр нөлөөг (орчин ба нийгмийн хүрээнд) ойлгох чадвар эзэмших
13	Мэргэжилтэн гаргах шийдвэрийнхээ үр нөлөөг (салбар болон бизнесийн хүрээнд) ойлгох чадвар эзэмших
14	Мэргэжлийн болон удирдлагын түвшинд сэтгэн бодох чадвар
15	Үйл ажиллагааг төлөвлөх чадвар эзэмших
16	Хэрэгжүүлэх, бүтээх чадвар
17	Хэрэглээ болгох чадвар эзэмших
18	Мэргэжлийн манлайлах чадвар эзэмших
19	Интерпренершип

Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives)

1. Сатематик ба байгалийн шинжлэх ухааны болон Уул уурхайн машин тоног төхөөрөмжийн суурь мэдлэгүүдийг олгох ба хөгжүүлэх
2. Үйлдвэрлэл болон нийгмийн бүхий л салбарт инженер техникийн асуудлыг шийдвэрлэх, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх замаар шинэ мэдлэг бүтээх, бүтээлч хандлага бүхий тасралтгүй хөгжих чадвартай мэргэжилтэн бэлтгэх төлөвшүүлэх, хөгжүүлэх
3. Төрөлх болон гадаад хэл дээр бичгээр ба харилцаагаар бусадтай ойлголцох, бусадтай нийцтэй хамтран ажиллах чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэх
4. Үйлдвэрлэлийн газар болон нийгмийн бусад салбарын хүрээнд шинэ санаа гаргах/conceive/, төлөвлөх /design/, хэрэгжүүлэх /implementation/ чадваруудыг хөгжүүлэх.

Хөтөлбөрийн төгсөгчийн загвар



- Инженерийн сэтгэлгээтэй, мэргэжлээрээ тасралтгүй хөгждөг, насан туршдаа суралцдаг
- Шинэ дэвшилтэт технологийг санаачлагч, хөгжүүлэгч, нэвтрүүлэгч
- Хувь хүний болон мэргэжлийн ёс зүйг эрхэмлэдэг, харилцааны ур чадвартай манлайлагч
- Инженерчлэл, симуляци ба загварчлал, програмчлалын цогц чадамжтай
- Машин тоног төхөөрөмжийн үр ашигтай ашиглалт, аюулгүй ажиллагааг хангагч

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

БСШУ-ы сайдын 2014 оны 04-р сарын 28-ны өдрийн “Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага батлах тухай” А/174 тоот тушаалд нийцсэн бүтэцтэй сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлдэг.

№	Хөтөлбөрийн багц цаг	Заавал судлах		Сонгон судлах		Нийт судлах	
		Кредит	хувь	кредит	хувь	Кредит	Хувь
1	Ерөнхий суурь хичээл (30% хүртэл)	33	25	6	28.6	39	30
2	Мэргэжлийн суурь хичээл (25%)	34	26	6	28.6	40	30.8
3	Мэргэшүүлэх хичээл (45% багагүй)	42	29	9	42.8	42	39.2
4	Дадлага					4+5	
5	Нийт дүн	109	84	21	100	130	100

Багшлах бүрэлдэхүүний нөөц, чадамж

УУСТТ хөтөлбөрийн хүрээнд нийт 23 багшийн нөөцийг бүрдүүлэн гэрээний үндсэн дээр ажиллуулж байгаагийн 13.6 хувь нь докторын зэрэгтэй байна. Үүнээс үндсэн 6 багш хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр багшилж байгаагийн 33.3 хувь нь докторын зэрэгтэй.

Хөтөлбөрийн багшлах бүрэлдэхүүнд 14-26 жил тогтвортой ажилласан АНУ, БНСУ-д мэргэжил дээшлүүлсэн туршлагатай мэргэшсэн, чадварлаг багш нар байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, мэргэжилтэнд тавигдах шаардлагад хийсэн STEEP шинжилгээ;
- Ажил олгогчидтой хийсэн уулзалтын протокол, 2018.03.25;
- Төгсөгчидтэй хийсэн цахим уулзалт;
- Ажил олгогчидтой хийсэн цахим уулзалт;
- Суралцагчидтай хийсэн уулзалт.

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- Уул уурхайн машин тоног төхөөрөмж” хөтөлбөрийг БСШУС-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Баклаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу боловсруулж, үндэсний болон олон улсын боловсрол, нийгэм эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн чиг хандлага, оролцогч талуудын хэрэгцээг хангахад чиглүүлэн шинэчлэлт, сайжруулалтыг хийдэг.
- Уул уурхайн салбарын хөгжлийн өнөөгийн байдал, бодлого, хүний нөөцийн судалгаа, мэргэжлийн ур чадварын барометрийн судалгааг нарийвчлан хийсэн.

Анхаарах асуудал:/Сул тал/

- Гадаадын их, дээд сургуулийн ижил төстэй хөтөлбөрийн харьцуулсан судалгаа хангалтгүй. Зөвхөн ОХУ-ын Белградын политехникийн коллежитэй харьцуулсан.
- Хөтөлбөрөөр судлах хичээлийн харьцуулсан судалгаа байхгүй.
- Хөтөлбөрийн оролцогч талуудаас асуулга, судалгааг тогтмол авч хэвшээгүй. (Ажил олгогчидтой 2018 онд ярилцлагын аргаар санал асуулга авсан.)
- Хөтөлбөрийн төлөвлөлт, шинэчлэл, сайжруулалтын асуудлыг мэргэжлийн тэнхимийн хурлаар хэлэлцсэн тухай хурлын тэмдэглэл байхгүй.

Үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Зөвлөмж:

- Гадаад, дотоодын ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлэгч их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр, түүний агуулга, бүтцийн харьцуулсан судалгааг сайжруулж, салбартаа тэргүүлэгч гадаадын их, дээд сургуулийн хөтөлбөрийн харьцуулсан судалгаа хийсний үндсэн дээр хөтөлбөрийн төлөвлөлтийг хийх.
- Хөтөлбөрийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч тэнхимээр хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэлийг хөтөлж хэвших.

Шаардлага:

- Хөтөлбөрийн төлөвлөлттэй холбоотой асуудлаар оролцогч талуудаас байнга асуулга, судалгаа авч, түүний мөрөөр арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлж хэвших.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- ЭЦДС-ийг 2014-2024 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө;
- УУМТТ хөтөлбөрөөр төгсөгчийн загвар;
- ЭЦДС-ийг төгсөгчдийн мөшгөх судалгаа, 2016 он;
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа, 2016 он;
- Төгсөгчидтэй хийсэн цахим уулзалт;
- Ажил олгогчидтой хийсэн цахим уулзалт;
- Суралцагчидтай хийсэн уулзалт;
- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, мэргэжилтэнд тавигдах шаардлагад хийсэн STEEP шинжилгээ;
- “Уул уурхайн машин тоног төхөөрөмж”, “Ашигт малтмалын баяжуулалтын технологи” бакалаврын хөтөлбөрийн төгсөгчийн загварыг тодорхойлж батлах тухай ЭЦДС-ийн хөтөлбөрийн дэд хорооны 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 2а тоот хурлын тэмдэгдэл.

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- Монгол Улсын боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, Боловсролын тухай болон дээд боловсролын тухай хууль, сургуулийн алсын хараа, эрхэм зорилго, хөгжлийн стратеги төлөвлөгөө, салбарын

хөгжлийн чиг хандлага, хүний нөөцөд тавигдах шаардлага зэргийг үндэслэн хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилго, 4 зорилтоо тодорхойлсон.

- Хөтөлбөрийн зорилго, зорилт хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилт, хөтөлбөрийн сургалтын үр дүн, хичээлийн сургалтын үр дүнтэй харилцан уялдсан.
- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээ, мэргэжилтэнд тавигдах шаардлагад хийсэн STEEP шинжилгээнд үндэслэн хөтөлбөрөөр төгсөгчийн загвараа тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, төгсөгчийн загварыг тодорхойлохдоо оролцогч талуудын санал, зөвлөмжийг тусгаж хэвшээгүй.
- Хөтөлбөрийн зорилго, өөрчлөлт, шинэчлэлийн талаар олон нийтэд хүргэсэн мэдээлэл ховор.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилго, зорилт, тэдгээрийн өөрчлөлтийг оролцогч талууд болон олон нийтэд мэдээлэх сувгийг тодорхой болгож, мэдээллийг шуурхай хүргэдэг байх;
- Хөтөлбөрийн зорилго, зорилт, төгсөгчийн загварыг тодорхойлох, түүнийг өөрчлөх, шинэчлэхэд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- Монгол Улсын шинжлэх ухаан технологийн их сургуулийн геологи, уул уурхайн сургуулийн “Механик инженер” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө (2016.06.27-ны өдрийн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар баталсан)
- Механик инженер хөтөлбөр боловсруулалтыг сайжруулах ажлын төлөвлөгөө, 2018.05.14
- Механикийн тэнхимийн хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө, 2019.10.28

- Сургалтын хөтөлбөр, мэргэжлийн нэр зэрэг батлах, сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай, ШУТИС-ийн захирлын тушаал А\237, 2019.11.23
- Механикийн тэнхимийн хурлын тэмдэглэл, 2022.03.14
- УУМТТ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, 2021 он;
- Уул уурхайн машин тоног төхөөрөмж хөтөлбөрийг шинэчлэх төлөвлөгөөний санал, (ШУТИС руу явуулсан) 2022 он;
- УУМТТ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн хөтөлбөрүүд;
- УУМТТ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн бүлэг сэдвийн төлөвлөлт;

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- УУМТТ хөтөлбөрийг 2002 оноос Эрдэнэтийн Технологийн Сургууль (хуучнаар) ШУТИС-ийн Уул уурхайн салбар, тэнхимийн сургалтын төлөвлөгөөг дамжуулан хэрэгжүүлж эхэлсэн.
- Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургууль (хуучнаар)-ийн хөтөлбөрийн хорооны 2018 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хурлаар нэгж хичээлийн хөтөлбөрийг өөрийн сургуулийн сургалтын орчин, нөхцөлд нийцүүлэн агуулгын 20 хүртэлх хувьд өөрчлөлт оруулах талаар хэлэлцүүлж, захирлын тушаалаар батлан анхны хувилбарыг боловсруулж, сайжруулан хэрэгжүүлж байна.
- БСШУ-ы сайдын 2014 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн “Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага батлах тухай” А/174 тоот тушаал, БШУ-ны сайдын “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” 2022 оны 5 дугаар сарын 09-ний өдрийн А/160 тоот тушаал зэрэг холбогдох хууль эрх зүйн акт, дүрэм, журамд нийцүүлэн сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.
- Хөтөлбөрийн үр дүнд (PLO) суурилан, хичээл тус бүрийн (CLO) суралцахуйн үр дүнг тодорхойлсон.
- Хичээлийн агуулга болон хүрэх үр дүнгийн хоорондын хөндлөн болон босоо залгамж холбооны хамаарлын матрицыг боловсруулан хяналт тавьж ажилладаг.
- Хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу байнга шинэчлэн сайжруулдаг.
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай дадлага хийлгэх тухай гэрээний дагуу хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд үйлдвэрлэлийн дадлагад 100 хувь хамрагдах боломжтой.
- Хичээлийн үр дүнгийн талаар суралцагчдаас тогтмол судалгаа авч, тухайн жилийн амжилт, чанар, корреляцийг өмнөх жилүүдтэй харьцуулан дүгнэлт хийж, зохих сайжруулалтыг тогтмол хийдэг.

Анхаарах асуудал: /Сул тал/

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг боловсруулахдаа оролцогч талуудын оролцоог бүрэн хангаж ажилладаггүй.
- Зарим хичээлийн хөтөлбөрт тухайн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагын ялгааг зөв гаргаж тодорхойлоогүй, хөтөлбөрийн болон хичээлийн үр дүнгийн хоорондын хамаарлыг буруу тодорхойлсон.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлага, сургалтын арга зүй, сургалтын үнэлгээний талаар оролцогч талуудын санал, зөвлөмжийг тогтмол авч, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлэх.

ШАЛГУУР 1.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- “Уул уурхайн машин тоног төхөөрөмж” хөтөлбөрийн бакалаврын сургалтын төлөвлөгөө (ЭЦДС-ийн сургалтын албаны дарга баталсан, 2023.03.23);
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т оюутан, суралцагчдыг дадлага хийлгэх журам”-ын 2 дугаар хавсралт, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-д үйлдвэрлэлийн дадлага хийлгэх тухай гэрээ;
- Ерөнхий захирлын 2021 оны 07 сарын 27-ны өдрийн А\343 тоот тушаалын 18 дугаар хавсралт. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т оюутан, суралцагчдыг дадлага хийлгэх журам”;
- Хичээл хоорондын залгамж холбоо харуулсан график (хөтөлбөрийн мод).

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- Хөтөлбөрийг үе шаттай тогтмол тасралтгүй сайжруулдаг.
- Нэгж хичээлийн бүлэг сэдвийн төлөвлөлт боловсруулан, тогтмол хэрэгжүүлдэг.
- Хичээл тус бүрийг 2-оос доошгүй багш заадаг бөгөөд оюутан багшаа сонгох боломж бүрдсэн.
- Оюутныг дадлага хийх, онолын сургалтыг практиктай хослуулан явуулах боломжийг бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:/Сул тал/

- Дадлага ажлын үр дүнд хийсэн анализ, шинжилгээ хийдэггүй.
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас өөр байгууллагатай дадлагын талаар хамтран ажиллах гэрээ байгуулаагүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээт байгууллагын тоог нэмэгдүүлэх;
- Дадлагын үр дүнг хянаж, шинжилгээ хийн үр дүнд үндэслэн сайжруулах арга хэмжээг авч хэвшүүлэх.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- Хичээлийн хөтөлбөрүүд;
- ЭЦДС-ийн Сургалтын үйл ажиллагааны журам;
- ЭЦДС-ийн цахим сургалттай холбоотой судалгааны нэгтгэл, 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирал;
- Суралцагчидтай хийсэн уулзалт.

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- Сургалтын үйл ажиллагаанд open EDX, Classroom, MS Teams зэрэг цахим платформуудыг ашиглан сургалтын агуулга, нэгж хичээлийн хөтөлбөрүүд, ашиглах ном, сурах бичиг, эх сурвалжуудыг бүрэн цахим хэлбэрт шилжүүлэн ашигладаг.

- “Unimis” удирдлагын мэдээллийн системийг ашиглан сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.
- Оюутныг үнэлгээг рубрикийн шалгуураар 1-5 түвшинд тодорхойлон түүнд тохирох даалгаврыг блүүмийн таксономийн 6 түвшингээр блюпринтийн дагуу хийдэг.
- Хичээл бүрт идэвхтэй сургалтын арга зүйг ашигладаг бөгөөд багш бүрийн сургалтдаа ашиглаж байгаа арга зүйд дүн шинжилгээ хийж, үүрэг даалгавар өгөн биелэлтийг хянаж ажилладаг.
- Суралцагчийн цагийн ачааллыг улирлаар тооцон гаргаж, хичээлийн хуваарийг удирдлага мэдээллийн системд байршуулдаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Сургалтын үйл ажиллагаа явуулах журам, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2021 оны 8 дугаар сарын 26-ны А\399 тоот тушаалын нэгдүгээр хавсралт;
- Улирлын шалгалт, төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах удирдамж. 2023.12.11;
- УУМТТ хөтөлбөрөөр суралцагчдын дүнгийн анализ, хичээлийн жилийн хаврын болон намрын улирал тус бүрээр;
- 2023-2024 оны хичээлийн жилийн 30 онооны шалгалтын даалгаврын санг Блүүмийн таксономийн түвшингээр боловсруулсан үр дүнг хичээлийн үр дүнтэй харьцуулсан анализ;
- Багш нарын сургалтын үйл ажиллагааны тайлангууд, улирлаар;
- Багшийн болон хөндлөнгийн үнэлгээний хоорондын хамаарлын корреляцийн шинжилгээ, улирлаар, хичээл тус бүрээр;
- ЭЦДС-ийн Сургалтын үйл ажиллагааны журам;
- Лабораторийн ажлыг үнэлэх үнэлгээний аргачлал;
- Хичээл тус бүрийн бүлэг сэдвийн төлөвлөлт, улирал бүрээр;
- Механик инженер мэргэжлийн (бакалаврын) хичээлүүд, оюутанд зориулсан гарын авлага, улирал тус бүрээр.

Онцлог зүйл:

- 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн хөндлөнгийн үнэлгээ буюу улирлын шалгалт авахдаа Блүүмийн таксономийн аргыг хэрэглэж ирсэн.
- 2022-2023 оны хичээлийн жилээс явцын үнэлгээнд Блүүмийн таксономийн аргыг хэрэглэдэг болсон.

- 2020-2021 оны хичээлийн даалгаврын сан бүрдүүлэхдээ Рубрикийн аргыг хэрэглэж эхэлсэн.
- Хөтөлбөрөөр суралцагчдын дүнд тогмтол шинжилгээ хийж, үр дүнд үндэслэн арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлдэг.
- Багшийн болон хөндлөнгийн үнэлгээний хоорондын хамаарлыг корреляцийн шинжилгээний аргаар тодорхойлж, сургалтын арга зүйг сайжруулж, шинэчлэх төлөвлөгөө боловсруулан ажилладаг.
- Хичээл тус бүрээр бүлэг хичээлийн төлөвлөлтийг улирлын эхэнд хийж, сургалтын албаны даргаар батлуулж мөрддөг. Үүнд, бүлэг сэдэв болон хөтөлбөрийн үр дүнгийн хоорондын уялдаа холбоо, хичээлд ашиглах арга аргачлал, хэрэглэгдэхүүн, сэдвээр эзэмших чадвар, суралцагчийн үнэлгээг тусган хэрэгжүүлж ажилладаг.

Үнэлгээ: Бүрэн хангасан

ШАЛГУУР 2.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- ХАБЭА-н иж бүрэн үзлэг, шалгалтын үр дүнгээр авах арга хэмжээний тухай ЭЦДС-ийн захирлын тушаалууд;
- ЭЦДС-д 2023 оны 9 дүгээр сарын 11-14-ний өдрүүдэд явагдсан ХАБЭА-н 4 дүгээр шатны иж бүрэн хяналтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөө;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ХАБЭА-н хэлтсийн албан шаардлагууд;
- Итгэмжлэгдсэн лабораториудын сорилын дүн.

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний үйл ажиллагаа нь ЗХУ-ын Барилгын эрдэм шинжилгээ, зураг төслийн институтийн зураг төслийн даг уу баригдаж, 1975 онд ашиглалтад орсон өөрийн өмчлөлийн хичээлийн байранд явагддаг.

- Хөдөө орон нутгаас суралцаж буй оюутнуудын сурч, амьдрах таатай орчныг бүрдүүлсэн, стандартын шаардлага хангасан оюутны дотуур байртай.
- Эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан, мультимедиа /компьютер, проектор, ухаалаг самбар, дэлгэц зэрэг/ техник хэрэгслээр 100% хангагдсан, орчин үеийн интерактив сургалтын аргыг ашиглах боломж бүрдсэн хичээлийн анги танхимтай. Иж бүрэн тоноглогдсон сургалтын 12 лабораторитой.
- Сургалтын үйл ажиллагаа, сургалтын орчинд тавигдах ХАБЭА-н шаардлагыг боловсруулан мөрдөж, зөрчигдсэн тохиолдолд авах арга хэмжээг шуурхай төлөвлөн ажилладаг.
- Мэргэжлийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг таниулах загвар, моделиуд бүхий “Аюулыг таниулах төв”-ийг 2017 онд байгуулан сургалтад ашиглаж байна.
- 120-150 оюутны суудал бүхий шинжлэх ухаан технологийн сангийн уншлагын 2 танхимтай.

Анхаарах асуудал:

- Суралцагчдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ байхгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Суралцагчийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- Оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа, хичээлийн жилүүдээр;
- Суралцагчидтай хийсэн уулзалт;
- ЭЦДС-ийн цахим сургалттай холбоотой судалгааны нэгтгэл, 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирал;
- Багшийн ажлын тайлан, хичээл жил бүрээр.

Онцлог зүйл:

- Онлайн сорил, шалгалтыг Google-Forms-д, цахим хичээлийг Open-edx платформд тус тус байршуулан цахим материалыг суралцагчид ашиглах боломжоор бүрэн хангасан.

- 2009 онд ШУТИС, ЭҮТӨҮГ, ЭЦДС-ийн хооронд Зайн сургалт явуулах иж бүрдэл тоног төхөөрөмж бүхий танхимыг байгуулан ашиглаж байгаа.
- Оюутнуудад хэрэглээний программ хангамжуудыг эзэмшүүлэх, виртуал хичээл заах, төслийн ажил гүйцэтгэхэд зориулсан 75 компьютер бүхий 3 виртуал лабораторитой.
- Лекцийн бүх анги, танхимыг орчин үеийн мультимедиа техник хэрэгслээрээ /LCD/DLP проектор, дэлгэц зэрэг/ бүрэн тоногдсон болно
- 2020 оноос Open edx программыг ашиглан сургалтыг цахим, танхим хосолсон хэлбэрээр явуулж, улирал бүр үр дүнг гарган сайжруулах ажлуудыг хийж байна.
- ЭЦДС-ийн багш бүр улирлын төгсгөлд тухайн улиралд заасан хичээлийнхээ бүлэг сэдвийн агуулга, даалгаврын сан, тоног төхөөрөмж, ном сурах бичгийн хэрэглээ, хэрэглэгдэхүүний тохирц, гүйцэтгэл, хэрэгжилтийг тайлагнадаг.

Анхаарах асуудал:/Сул тал/

- УУМТТ мэргэжлийн программ хангамж бүхий компьютерийн хүрэлцээ, хангамж муу.
- Интернетийн хурд, сургалтад ашиглаж буй компьютерийн хүчин чадал хангалтгүй, утасгүй сүлжээний хамрах хүрээ хязгаарлагдмал.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Сургуулийн орчны интернетийн хурд, утасгүй интернетийн сүлжээний хүртээмжийг (wi-fi) нэмэгдүүлэх;
- Сургалтад ашиглаж буй компьютерийн шинэчлэлд анхаарч ажиллах..

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- ЭЦДС-ийн захирлын 2021 оны 08 дугаар 26-ны өдрийн А\93 тоот тушаалын 11 дүгээр хавсралт, ЭЦДС-ийн номын сангийн журам;
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, улирал бүрээр;
- Номын сангийн катологи.

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- <https://www.research4life.org/> олон улсын судлаачдын нэгдсэн сан, <https://lib4u.online/?lib=must>, ШУТИС-ийн номын сангийн электрон каталог, www.greenstone.eit.edu.mn “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийн электрон каталоогоор дамжуулан судалгааны ажлууд болон сурах бичгийг ашиглах боломжтой.
- Үүлэн технологид суурилсан номын сангийн автоматжуулалтын LIB4U программ, олон улсад ашигладаг номын сангийн GREENSTONE программ, ШУТИС-ийн удирдлагын мэдээллийн UNIMIS системийн номын сангийн E-LIBRARY дэд программыг номын сангийн үйлчилгээнд ашигладаг.
- Хөтөлбөрөөр суралцагсад нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдэд ашиглах ном, үндсэн сурах бичиг, нэмэлт гарын авлага, материалуудаар хангагдсан. Номын сангийн фондод шинжлэх ухааны бүх салбарыг хамарсан нийт 42533 ширхэг ном сурах бичиг байгаа ба номын фондыг жилд дунджаар 1000 гаруй шинэ номоор баяжуулан ашиглаж байна.
- Нийтийн, эрдэм шинжилгээ болон тогтмол хэвлэлийн, оюутны байрны уншлагын танхим бүхий 280 м2 талбайтай номын сантай.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн ном, сурах бичгийн шинэчлэл хангалтгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: /Анхаарах асуудалд чиглэсэн байна/

- Сүүлийн үед гарсан мэргэжлийн ном сурах бичгийн тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах.

ШАЛГУУР 3.

ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- Хөтөлбөрийн хороо байгуулах тухай ЭЦДС-ийн захирлын 2014 оны 05-р сарын 14-ний өдрийн А/36 дугаар тушаал;
- Хөтөлбөрийн хороог шинэчлэн байгуулах тухай ЭЦДС-ийн захирлын 2023 оны А/48 тушаал;
- Санал гомдлын хороог байгуулах тухай ЭЦДС-ийн захирлын А/148 тушаал;
- ЭҮТӨҮГ-т гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх журам;
- ЭЦДС-ийн “Санал, гомдлын хорооны ажиллах журам” ;
- ЭЦДС-ийн цахим сургалттай холбоотой судалгааны нэгтгэл, 2020-2021 оны хичээлийн жилийн намрын улирал;
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа, улирал бүрээр;
- ЭЦДС-ийн удирдлагын мэдээллийн UNIMIS систем.

Онцлог зүйл:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийг удирдлага, багш, суралцагчид бүрэн ашиглаж хэвшсэн.
- Холбогдох сургалт, удирдлагын үйл ажиллагааны шат бүхэнд дэвшилтэд мэдээллийн систем, технолого, программыг ашигладаг

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хариуцсан тэнхимийн баг ажилладаг

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

Тэнхимийн хөтөлбөрийн багийг хөтөлбөрийн хороо болгон өргөжүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулах.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын санхүү, эдийн засаг хариуцсан орлогчийн ЭЦДС-ийн ажилчидтай хийсэн уулзалтын үеэр гаргасан саналуудыг хэрэгжүүлэх механикийн тэнхимийн төлөвлөгөө, 2020.02.21;

- Механикийн тэнхимийн үйл ажиллагааны тайлан, хичээлийн жил бүрээр
- Механикийн тэнхимийн үйл ажиллагааны төлөвлөгөө, оноор;

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- Дотоод хамтын ажиллагаа, түншлэлийн хүрээнд олон чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- ЭЦДС-ийн багш, ажилчид нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр Эрдэнэт хотын хуваарилагдсан зам талбайн цас, мөсийг цэвэрлэдэг. Мөн иргэд болон сонирхогч талуудад мэргэжлийн сургалтын үйлчилгээг үзүүлдэг.

Анхаарах асуудал:

- Төлөвлөгөөг оноор, тайланг хичээлийн жилээр гаргадаг тул үр дүнг үнэлэхэд хүндрэлтэй.
- Гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хэлэлцээрийн хугацаа дууссан (1-ээс бусад). Мэргэжлийн холбоод, ТББ-тай хамтын ажиллагаа сул.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд ЭЦДС-ийн багш, ажилчид, суралцагчид сайн дурын ажилд оролцох идэвх сул.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Төлөвлөгөө, тайлангийн хугацааны уялдаа холбоог хангах боломжийг судалж, шийдвэрлэх.
- Нийгэмд чиглэсэн сайн дурын ажилд идэвхтэй хамрагдах, хамт олныг идэвхжүүлэх тал дээр анхаарч ажиллах.
- Гадаад болон мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааны гэрээ, хэлцэл байгуулж багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг олон хэлбэрээр хамтран ажиллах.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан;
- ЭЦДС-ийн 2023-ны үйл ажиллагааны тайлан;
- ЭЦДС-ийн Санхүүгийн байдлын тайлан, 2023 он;
- ЭЦДС-ийн 2023 оны орлогын төлөвлөгөө.

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- Санхүүгийн олон талт эх үүсвэрийг бүрдүүлж чадсан. 2023 оны байдлаар үндсэн сургалтаас гадна Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын бусад цех, хэлтсүүдэд 10 төрлийн сургалт явуулж орсон орлого 41.8 хувь, эрдэм шинжилгээ нь 12.5 хувь, бусад орлого 2.2 хувь байна.
- Багшийн хөгжил, мэргэжил дээшлүүлэх болон судалгааны ажил, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн санхүүжилт нь сургуулиас төлөвлөсөн хэмжээгээр Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Үйлдвэрлэлийн мэргэжил дээшлүүлэх зардалд тусгагддаг.
- ЭЦДС-ийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад 32.8 сая төгрөг зарцуулсан. Багш, ажилчдын нийгмийн тусламж, дэмжлэгийн хүрээнд 2023 онд 7.8 сая төгрөг олгосон нь өмнөх оноос 0.6 хувиар өссөн.
- Багш нар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хөдөлмөрийн гэрээ байгуулж цалинждаг.

Анхаарах асуудал:/Сул тал/

- Багшийн хөгжилд зарцуулах санхүүжилтийн хэмжээ хангалттай боловч “Багшийг хөгжлийн сан”-г зохих журмын дагуу тусгайлан байгуулж зарцуулдаггүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

- Зохих журмын “Багшийн хөгжлийн сан” байгуулж зарцуулдаг болох.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- Технологийн сургуулийг 2014-2024 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө;
- “Эрх шилжүүлэх тухай” ЭҮТӨҮГ-ын ерөнхий захирлын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/761 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт (Математик-байгалийн ухааны олимпиад зохион байгуулдаг);
- Сургуулийн цахим хуудас.

Онцлог зүйл:

- Жил бүр “Мэргэжил сурталчлах аялал”-ыг зохион байгуулдаг.
- ЭЦДС-ийг 21 аймагт таниулах, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор ЭЦДС-ийн цахим

хуудас болон Youtube сувгаар дамжуулан EIT PODCAST-ыг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн тогтмол хүргэж байгаа.

Анхаарах асуудал:/Сул тал/

- Хөтөлбөрийг хөгжүүлэхэд чиглэсэн тандалт, судалгаа хийдэггүй, хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангахуйц төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлдэггүй.
- Хөтөлбөрийн сурталчилгаа хангалтгүй.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж: Хөтөлбөрийг хөгжүүлэхэд чиглэсэн тандалт судалгааны үндсэн дээр төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо: /шаардлагатай холбоотой тоо баримт, танилцсан мэдээлэл бичнэ/

- Хөтөлбөрийн ӨҮТ;
- ЭЦДС-ийн захирлын 2021 оны 07 сарын 22-ны өдрийн А/87 дугаар тушаалын хавсралт “ЭЦДС-ийн мэдээлэл харилцааны журам”;
- Сургуулийн цахим хуудас;
- УУМТТ 2011 фэйсбүүк пэйж хуудас.

Онцлог зүйл: /Давуу тал, сайн туршлага г.м/

- Сургуулийн үйл ажиллагаа, багш, ажилтан, оюутан, суралцагчдын талаарх албаны мэдээллийг Орхон аймаг, ЭҮТӨҮГ болон өөрийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдээр олон нийтэд нээлттэй, ил тод, шуурхай хүргэж ажилладаг.
- УУМТТ хөтөлбөрийн элсэлт бүрээр фэйсбүүк групп нээж, холбогдох мэдээллийг хүргэн ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх мэдээллийн суваг хязгаарлагдмал, мэдээллийн ил тод байдал хангаагдаагүй. Зөвхөн сургуулийн вэб хуудсанд тогтмол хуучирсан мэдээлэл байршуулсан.

Үнэлгээ: Бүрэн хангасан

Зөвлөмж:

